



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 26 өдөр

Дугаар 1418

Арвайхээр сум

Шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.6, аймгийн Засаг даргын 2008 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 165 дугаар захирамжаар батлагдсан “Нэрэмжит шагналын журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Зэвсэгт хүчин, хууль хяналтын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, аймаг орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулж буй Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн захирагч, хурандаа Н.Гүрбадам, аймгийн Прокурорын газрын дарга, хууль цаазын шадар зөвлөх Б.Эрхэмбаатар нарыг Богд хаант Монгол Улсын анхны Ерөнхий сайд агсан Т.Намнансүрэнгийн нэрэмжит “Төрийн шилдэг түшээ” тэмдгээр шагнасугай.

2.Шагналд дагалдах “Төрийн шилдэг түшээ” тус бүр 100,000 (нэг зуун мянга), нийт 200,000 (хоёр зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0816

D:My Doc. Zahiramj. Zasag darga